



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/212

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Ш.Баасанжав (ГЮ46101167)-гийн Булган сум 5 дугаар баг Д.Дамбын 2 дугаар гудамж 213 тоотод байршилтай 6308003688 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 356 м2 газрын газар эзэмших эрхийг Д.Золбаяр (ГЮ80022152)-т, Ч.Чинзориг (ГЗ84022411)-ийн Булган сум 5 дугаар баг Д.Дамбын 1 дүгээр гудамж Г10 тоотод байршилтай 6308002375 нэгж талбар бүхий автомашины гараашийн зориулалтаар эзэмшиж буй 36 м2 газрын газар эзэмших эрхийг Б.Төмөр-Очир (ГЮ69030569)-т тус тус шилжүүлсүгэй.

2. Д.Золбаяр, Б.Төмөр-Очир нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 358 дугаар захирамжийн Ш.Баасанжав, 2022 оны А/75 дугаар захирамжийн Ч.Чинзориг нартай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ